



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2017 оны 04 сарын 18 өдөр

Дугаар 50

Номгон

“Корунд-Гео” ХХК-ний үйл ажиллагааг
дэмжиж, хувь эзэмших тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3 “е”, “ж” заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.4 дэх заалт, 78 дугаар зүйлийн 78.2.3 дахь заалт, Корунд Гео ХХК-ийн 2017 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 02 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлтийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Иргэн Б.Лхагважавын 100 хувийн эзэмшилтэй “Корунд-Гео” ХХК-ний эзэмшлийн 20 хувийг аймагт өгөх саналыг зохих хууль, тогтоомжийн дагуу судалж үнэ төлбөргүйгээр шилжүүлэх, цаашид хамтран ажиллахаар ирүүлсэн саналыг дэмжсүгэй.

2. Орон нутгийн өмчийн оролцооны хувь хэмжээ хариуцсан албан ёсны төлөөлөгчөөр “Баянхонгор Нью Майнинг” орон нутгийн өмчит ХХК-ийг томилсугай.

3. Аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-д даалгах нь:

3.1. “Корунд-Гео” ХХК-ийг орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж болгон зохион байгуулж, ажлын хэсэг гаргаж хуулийн хүрээнд хамтран ажиллах гэрээ байгуулж ажилласугай.

3.2. Орон нутгийн өмчийн оролцоотой “Корунд-Гео” ХХК-д Уул уурхайн сайдын 2015 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 10 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан “Тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулах журам”-ын 1.6 дахь заалтын дагуу сонгон шалгаруулалтад давуу эрхтэй оролцуулах, хайгуулын тусгай зөвшөөрөл олгуулах саналыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал, газрын тосны газарт уламжилсугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуян/-д даалгасугай.

ДАРГА

Ц.ОТГОНБАЯР



D;2017-togtool2017

116070